



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/1438

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн иргэдийн бүлгүүдийн амьдрах орчноо сайжруулах, дүүргийн өнгө үзэмж, тохижилтод хувь нэмэр оруулах зорилгоор хэрэгжүүлсэн тохижилтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга А.Түмэннасан
Баянзүрх дүүргийн хөгжлийн төвийн дарга

Гишүүд: Д. Бадамцэцэг
Тамгын газрын хөрөнгийн нягтлан бодогч
Д.Сарантуяа
Санхүү, төрийн сангийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
О.Түвшинтөгс
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Тохижилт, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн
Х.Азжаргал
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Зам барилга байгууламж, тээвэр, холбоо хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг: Г.Батхишиг
Баянзүрх дүүргийн хөгжлийн төвийн төсөвчин

2. Дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн тохижилтын ажлыг акт үйлдэн баримтжуулан Тамгын газарт хүлээлгэн өгөхийг Ажлын хэсэг /А.Түмэннасан/-д, Тамгын газрын өмчид бүртгэн, хүлээн авч ашиглалт, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Тамгын газар /Б.Амартүвшин/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Т.Батцогтод даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ